МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр Дугаар А/302 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулж, тов тогтоох,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Намрын өнгө-Хөдөлмөрийн шим 2022", Хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг худалдааг 2022 оны 09 дүгээр сарын 29-ны өдрөөс 09 дүгээр сарын 30-ны өдөр Чингүнжавын талбайд зохион байгуулахаар тогтоосугай.

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулах, шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээтэй холбогдон гарах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээний зардлын 9,000,000 (Есөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээлэл суртчилгааны зардлаас 3,000,000 (Гурван сая) төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэрлэсэн жилийн төсвөөс гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

4. "Намрын өнгө-Хөдөлмөрийн шим 2022", Хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг худалдааны бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, дотоод, гадаадын зах зээлд гаргах боломжийг бүрдүүлэх.

5. Иргэд, олон нийтэд сурталчлах, төсөлд оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулж, төслийн үр дүнг дээшлүүлэх, удирдамжийн дагуу зохион байгуулж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

6. Үзэсгэлэн яармаг худалдаанд орон нутгийн бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарыг дэмжин, бэлтгэл зохион байгуулалтыг ханган оролцуулахыг сумдын Засаг дарга, холбогдох агентлаг, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

My Doc/ loot A-4

Аймгийн Засаг даргын 2022 оны
09 дүгээр сарын 13.өдрийн А/302 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

"НАМРЫН ӨНГӨ-ХӨДӨЛМӨРИЙН ШИМ 2022", ХӨДӨЛМӨРИЙН ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ,ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунтуяа-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлстийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Ж.Сарангэрэл-(Худалдаа аж үйлдвэрийн танхим дарга)

Д.Батцоож-(Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга)

Н.Үүрийн цолмон -(Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол хүнсний хяналтын хэлтсийн дарга, Улсын ахлах байцаагч)

Д.Цэцэгмаа-(Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

П.Эрдэнэсайхан-(ХХААГ-ын хүнсний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ч.Ганчимэг-(Мөрөн сумын хүнс худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

Б.Цэцгээ-Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг

Нарийн бичгийн дарга:

Б.Буянтогтох-(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

_____oOo_____

Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын .13.. өдрийн А/302 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

"НАМРЫН ӨНГӨ-ХӨДӨЛМӨРИЙН ШИМ 2022", ХӨДӨЛМӨРИЙН ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Шагналын төрөл	Тоо хэмжээ	Шагнал	Тус брийн мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
1	Аймгийн шилдэг бүтээгдэхүүн	1	Батламж цом	1,000,000	1,000,000
2	Орон нутгийн онцолгийг харуулсан шилдэг бүтээгдэхүүн	3	Өргөмжлөл	500,000	1,500,000
3	Шилдэг технологитой бүтээгдэхүүн	1	Өргөмжлөл	500,000	500,000
4	Импортыг орлох бүтээгдэхүүн	1	Өргөмжлөл	500,000	500,000
5	Шилдэг гар урлал болон оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	3	Өргөмжлөл	500,000	1,500,000
6	Шилдэг үйлдвэрлэгч сум	1	Өргөмжлөл	1,000,000	1,000,000
7	Шилдэг зохион байгуулалттай сум	1	Өргөмжлөл	1,000,000	1,000,000
8	Шилдэг хоршоо, бүлэг	2	Өргөмжлөл	400,000	800,000
9	Баялаг бүтээгч өрх	5	Өргөмжлөл	200,000	1,000,000
10	Шилдэг газар тариалан эрхлэгч	3	Өргөмжлөл	500,000	1,500,000
11	Тайз чимэглэх зардал				500,000
12	Өргөмжлөл, батламж	21		40,000	840,000
13	Цом	1		60,000	60,000
13	Үйл ажиллагааны бусад зардал				300,000
	Нийт				12,000,000

_____oOo_____